


Тус сургууль өнөөгийн байдлаар 18 мянга гаруй ном бүхий номын сан, 1288 суудалтай хичээлийн 4 байр, 49 ортой гэрээт оюутны дотуур байр, 21 компьютер бүхий шилэн кабелиар холбогдсон интернет өрөө, 100 суудалтай чөлөөт сонголттой уншлагын заал, 14 лаборатори бүхий байгууламж ахуйн хангамжтай ажиллаж байна.

Одоогийн байдлаар 1 оюутанд 20 ном, сурах бичиг, 2.2 м<sup>2</sup> талбай бүхий хичээлийн байр, 62.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж оногдож байна.

Манай оюутнууд дархлал сэргээх, элэг хамгаалах, бөөр хамгаалах, хавдрын эсрэг үйлчилгээтэй “Эллипин”, “Нефромон”, “Салимон” зэрэг эмийн судалгаанд оролцох, тэдгээрийн химийн бүтэц найрлага, биологийн идэвхит бодисын үйлдлийг тогтоох, амьтан дээр туршилт сорилт гүйцэтгэх бүх ажилд оролцохын зэрэгцээ клиникийн нөхцөлд бэлдмэлээ өвчтөн дээр хэрэглэж ажиглалт явуулан, онолын болон эмнэлзүйн хичээл дээр олж авсан мэдлэгээ практик дээр баяжуулах боломж бололцоо бий болсоор байна.

2011 оны байдлаар манай сургууль 6 удаа төгсөлт хийж УАУ-ы их эмч мэргэжлээр 210 мэргэжилтэн амжилттай төгсгөсөн байна. Мөн 31 АУ-ы магистр манай сургуулийн хананд эрдмийн зэргийн ажил бичиж хамгаалсан байна.

### Сургуулийн зохион байгуулалтын бүдүүвч



асуудлыг санхүүтэй хамтран шийдэх, дадлагын тайлан хамгаалалтыг мэргэжлийн тэнхим багш нартай хамтран зохион байгуулах

- Ном, сурах бичгийн хангамж, хүрэлцээг байнга судлан, номын фондын тоог жил бүр нэмэгдүүлэх
- Багш бүрийн өөр өөрийн хичээлээр боловсруулсан тулгуур асуудлууд, дадлагын хичээлийн алгоритм, үйлдвэрлэлийн дадлагын удирдамжуудыг нэгтгэн товхимол болгох, номын сангаар дамжуулан оюутнуудад хүргэх
- Сургуулийн үйл ажиллагаа, сургалтын технологийн онцлог, шинэчлэлийн талаар реклам, PR, мэдээлэл хийх

Сургалтын ерөнхий зохион байгуулалт, сургалтын чанар, хичээлийн үр өгөөж, практик ач холбогдол, багш нарын хичээл заалт, харилцааны соёлын талаар Оюутан та бүхэнд санал хүсэлт байвал Сургалтын албан албан ёсоор хандаж болно.

“Монос” дээд сургуулийн УАУ-ы сургуулийн Сургалтын алба нь хичээлийн 2-р байрны 202 тоот өрөөнд байрладаг. Харилцах утас: 70170037

### **Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний алба**

ДХШУА нь 2007 оны 9-р сарын 1-нээс 2 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Тус албаны зорилго:


Монос дээд сургууль дээр боловсролын болон бусад холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтэнд хяналт тавих, сургуулийн нэгж салбар бүрийн ажлын явц, чанар, тэдгээрийн хоорондын ажил үүргийн уялдаа холбоо, багш ажилтнуудын ажлын хариуцлага, сургалтын орц, явц, гарцын үр дүнд байнгын хяналттавьж, ажлын ололтыг бататгах, алдаа дутагдал, доголдлыг цаг алдалгүй илрүүлж, түүний шалтгааныг тогтоосны үндсэн дээр уг гажигдлыг засах, хөгжих сэдэл тэмүүллийг үүсгэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Тавигдах шаардлага:

- Тодорхой зорилго чиглэлтэй, агуулга хэлбэрийн хувьд уян хатан байх
- Үнэлгээний шалгуур нь ойлгомжтой нээлттэй ил тод байх
- Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг хослуулсан хамтын хэлбэртэй байх
- Амжилтыг нээн илрүүлэх цаашдын ажлыг тодорхойлоход чиглэсэн байх
- Үнэлгээ нь тодорхой, бодитой, шударга байх
- Сургуулийн өөрийн үнэлгээ болон багш, суралцагсдын үнэлгээг харгалзах
- Санаачлага хөгжлийг дэмжих хөшүүрэг болохуйц байх

тэнхимүүдтэй байнга хамтран ажиллах зэрэг хэлбэрээр оюутан нэг бүртэй тулж ажиллах зорилт тавин ажиллаж байна.

### Оюутанд үзүүлэх үйлчилгээний зохион байгуулалтын бүдүүвч



#### 1. Сургалт:

Манай сургуулийн УАУ-ы ангийн бакалаврын түвшингийн сургалтанд 2009-2010 оны хичээлийн жилд 600 гаруй оюутан хамрагдаж байна.

Үйлдвэрлэлийн мэргэшүүлэх дадлагыг сургалтын төлөвлөгөөнд заагдсаны дагуу II курсээс эхлэн явуулдаг. УАУ-ы ангид II курст сувилахуйн дадлага, эмийн ургамлын нөөц, тархалт, тарималжуулалт, систематикийн дадлага гэсэн 2 дадлага хийгддэг. III курст бага эмчийн дадлага, IV курст туслах эмчийн дадлага, V курст УАУ-ы оношлогоо эмчилгээ, заслын дадлага (БНХАУ-д), VI курст өрхийн эмчийн дадлагыг тус тус хийдэг. Эдгээр дадлагууд “Хулжборжигон” эмнэлэг, ТТАХНЭ, ХУД-ийн ЭМН, Энэрэл эмнэлэг, КТЭ-ийн цус, дотоод шүүрлийн булчирхайн клиник, уушги судлалын клиник, ЭНЭШТ-ийн эх барих, эмэгтэйчүүдийн клиник, ХСҮТ, ХӨСҮТ зэрэг клиникийн төв эмнэлгүүд түүний тасгууд дээр хийгддэг.

#### 2. Мэдээлэл:

Сургуулийн номын сан нь 39 м<sup>2</sup> талбай бүхий үндсэн фонд, 133.3 м<sup>2</sup> талбай бүхий уншлагын танхимд үйлчилгээ явуулж байна. Нийт 15697 номтойгоос 7528 буюу нийт номын 52% нь сурах бичиг, гарын авлагууд эзэлж байна.

Номын сангийн фондын бүх номыг CD ISIS программ дээр электрон каталогид оруулж нийт уншигчдад үйлчилж байна.

Мэргэжлийн болон ерөнхий эрдмийн гол гол хичээлүүдийн сурах бичгээр нийт оюутнуудын 70-80 хувийг хангаж ажилладаг. Монос дээд сургууль нь өөрийн гэсэн сургалтын онцлогтоо тохирсон сурах бичиг, гарын авлагыг бичиж хэвлүүлэх үүднээс жилд 3-5 орчим шинэ ном, сурах бичиг хэвлүүлж, оюутны гар хүргээд байна.

байлдагч нарыг хамруулан явагддаг нь хоёр байгууллагын хамтын ажиллагаанд болон оюутны мэдлэг, чадвар, сэтгэмжийн хүрээг тэлэхэд зохих хувь нэмрээ оруулдаг юм.

Оюутны алба нь хичээлийн 4-р байрнд байрладаг. Утас: 63-56-64

### **Санхүү, аж ахуйн алба**

2000 онд сургууль байгуулагдаж байхад сургууль өөрийн гэсэн санхүү, аж ахуйн албагүй байсан. Сургууль үйл ажиллагаагаа Моносфарм эмийн үйлдвэрийн байрны 3-р давхарт эхлүүлж байсан учир санхүү, аж ахуйн асуудлыг үйлдвэрийн энэ чиглэлийн нэгж салбарууд нуруундаа үүрч байсан.

Монос сургууль өсч тэлэхийн хирээр өөрийн гэсэн санхүү, аж ахуйн албатай болох зайлшгүй шаардлага гарч ирсэн. Ингээд 2003 оноос сургууль санхүү, аж ахуйн хувьд үйлдвэрээс тусгаарлаж, өөрийн нягтлан бодогч, няравтай болсон. Монос дээд сургуулийн анхны нягтлан бодогчоор Э.Нарантуяа, няраваар Л.Даваа нар ажиллаж эхэлсэн.

Одоо Монос дээд сургууль барилга байгууламж, тоног төхөөрөмж, эдлэн газрын хувьд өргөжихийн хирээр санхүү, аж ахуйн алба нөсөр том штаттай алба болж өргөжсөн байна:

Аж ахуйн дарга – Ё.Жаргалсайхан

Сургуулийн нягтлан бодогч - Э.Нарантуяа

Кассын нярав – С.Март

Аж ахуйн нярав – Э.Цэнгэлбаяр

Сантехникч - Н.Эрдэнэбадрах

Цахилгаанчин – Батбаяр

Жижүүр – Д.Эрдэнэбат

Жижүүр – З.Ганбаатар

Жижүүр – М.Энх-Амгалан

Жижүүр – Пүрэвдаваа

Жижүүр - Сумъяа

Үйлчлэгч - С.Хандсүрэн

Үйлчлэгч - Л.Лхамжав

Үйлчлэгч - Цэцэгмаа

Гадна талбайн үйлчлэгч - Адъяа

Лаборант - Халтар

1. Уншигч танхимд орохдоо гар тээш, цүнх, тор савтай зүйлийг орох хаалганы дэргэдэх тээшийн саванд хийж, номер авч орох ба гарахдаа номероо үйлчлэгчид өгч, тээшийн савыг онгойлгуулан эд зүйлээ авна.
2. Гадуур хувцастай уншигчид үйлчлэхгүй.
3. Уншлагын танхимд орохын өмнө гар утсаа заавал унтраана.
4. Уншлагын танхимд бохь авч орох, бохь зажлахыг хатуу хориглоно.
5. Уншигч танхимд орохдоо уншигчийн үнэмлэхээ таниулж орно.
6. Уншлагын танхимд зөвхөн дэвтэр, цаас, үзэг балтай орохыг зөвшөөрнө.
7. Уншигч хэрэгтэй номоо өөрөө чөлөөтэй сонгож ашиглах боловч нэг удаа тавиураас 2-оос илүүгүй ном авч ашиглахыг зөвшөөрнө. Авсан номоо **“Ном буцаах тавиур”** дээр тавьсаны дараа дараачийн номыг авч ашиглахыг зөвшөөрнө.
8. Уншлагын заалнаас гарахдаа хэрэглэсэн номоо **“Ном буцаах тавиур”** дээр тавьж, гарах хаалганы дэргэдэх соронзон хаалгаар шалгуулж гарна.
9. Уншлагын танхимд үймүүлэх, чанга ярих, холхих, гар утас, хөгжим дуугаргах, хамтарч ярьж хичээл ном давтах, хог тарих зэргээр бусдад саад учруулах, уншлагын танхимын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахыг хатуу хориглоно.
10. Уншлагын танхимд идэх уухыг хатуу хориглоно.
11. Уншлагын танхим доторх бие засах газар, цайны газарт ном авч орохыг хатуу хориглоно.
12. Дээрх заалтуудыг зөрчсөн тохиолдолд **номын сангаар** үйлчлүүлэх эрхийг 1-3 сараар хасна.
13. Номын хуудас урах, хулгайлах, уншлагын танхимын эд хогшлыг гэмтээх, ширээн дээр бичих эрээчих, үүдний шкафны түлхүүрийг эвдэх, өлгүүрийн болон хувцасны номероо гээх зэрэг үйлдэл хийвэл гэмтээсэн эд барааг 3 нугалж төлүүлэх ба **уншлагын танхимаар** үйлчлүүлэх эрхийг бүрмөсөн хасна.

## Морфо-физиологийн тэнхимийн танилцуулга



Монос АУДС-ийн Морфо-физиологийн тэнхим нь 2001-2002 оны хичээлийн жилд анх байгуулагдаж, тэнхимийн эрхлэгчээр нь АУ-ны магистр Д.Сарангэрэл томилогдон, Морфологийн багш АУ-ны магистр Х.Гэрэл, Эмгэг физиологийн багш АУ-ны магистр Б.Амаржаргал нарын бүрэлдэхүүнтэйгээр анхны тулгын чулууг тавьж, тус тэнхимийн түүхийг эхлүүлж байжээ.

Одоо нийт 5 багшийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна .

### **Тэнхимийн эрхэм зорилго:**

Мэргэжлийн суурь хичээлүүдийн зайлшгүй мэдсэн байх суурь ойлголт, агуулгыг ЭШБТ болон сүүлийн үеийн шинжлэх ухааны шинэ ойлголтоор баяжуулан, лабораторийн туршилт дээр суурилан чанартай, үр өгөөжтэй, мэдлэгийн санд нь тус нэмэр болохоор, бүтээлчээр оюутнуудад эзэмшүүлж, цаашдаа эмнэлзүйн болон эмзүйн мэргэжлийн хичээлүүдийг онолын үүднээс шинжлэх ухааны үг хэллэг болон нарийн нийлмэл механизмуудыг ашиглан тайлбарлаж чаддаг байх хандлагыг оюутнуудад төлөвшүүлэхэд оршино.

### **2010-2011 оны хичээлийн жилийн зорилт:**

Хичээлийн агуулгыг ЭШБТ,  $x + g + s$  болон сүүлийн үеийн ШУ-ны ойлголтоор баяжуулж оюутнуудад үр өгөөжтэй чанартай хүргэх арга зам, арга барилыг эрэлхийлэн ажиллаж шинийг санаачлагч, манлайлагч хамт олон болцгоох.

### **Манай тэнхимийн бүрэлдэхүүн:**

**Тэнхимийн эрхлэгч** Д.Тунгалаг АУ-ны магистр /гар утас-99769991/

Багш: Р.Ёндонпэрэнгэй АУ-ны магистрант

Багш: Ц.Энхбат АУ-ны магистр /гар утас-99017910/

Багш: Д.Мөнхцэцэг АУ-ны магистр /гар утас-99048983/

Багш: Т.Сувдаа АУ-ны магистр /гар утас-98229282/

ТДСАДарга, ЭШТ-ийн захирал Ц.Мөнхтуяа:

- 2002-2003 онд ЭМШУИС-ийн төгсөлтийн дараах резидентурын сургалтанд хамрагдаж зүү төөнө заслын нарийн мэргэжил эзэмшсэн.
- 2005 онд ЭМШУИС-д “Дэгд-8 эмийн фармакологийн судалгааны дүн” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан.
- 2005-2009 онд МУИС, ХФ болон ЭМШУИС-ийн докторантурын сургалтанд хамрагдаж “Удвал навчит тавилгана (*Spiraea aquilegifolia* Pall)-ы фармакологийн судалгаа” сэдвээр АУ-ы докторын зэрэг хамгаалсан.
- 2006 оноос эхлэн тус тэнхмийн эрхлэгчээр ажиллаж байгаад, 2010-2011 оны хичээлийн жилд ЭШТ-ийн захирлаар ажиллаж байна.
- Уламжлалт эмийн түүхий эд, номхотгол, Уламжлалт эмийн жор найрлага хичээлүүдийг зааж байна.

УЭТЭ, УЭЖН хичээлийн өрөө нь хичээлийн 1-р байрны 107 тоотод байрладаг.

Багш Ж.Баттөгс:

2005 оны 09 сараас эхлэн тус тэнхимд багшаар ажиллаж байна.

- 2005 онд “Монос” ДС-ийг уламжлалт анагаах ухааны их эмч мэргэжлээр төгссөн.
- 2006 онд “Монос” ДС-д “Зигомон бэлдмэлийн элэг хамгаалах үйлдлийн гистоморфологийн судалгаа” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан.
- 2009-2010 оны хичээлийн жилд ЭМШУИС-ийн докторантурт элсэн суралцаж байна.
- “АУДҮ, НҮ нэршлийн орчуулга зүй”, “Уламжлалт анагаах ухааны оношлол судлал” хичээлүүдийг зааж байна.

Багш О.Самбуу:

2005 оны 09 сараас эхлэн тус тэнхимд багшаар ажиллаж эхэлсэн.

- 2005 онд “Монос” АУДС-ийг уламжлалт анагаах ухааны их эмч мэргэжлээр төгссөн.
- 2006 онд “Монос” АУДС-д “Диабетомон бэлдмэлийн чихрийн шижин өвчний эсрэг үйлдлийн судалгаа” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан.
- “Уламжлалт таван засал”, “Зүү засал” хичээлүүдийг зааж байна.
- 2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн БНСУ-д докторантурт суралцаж байна.
- “Уламжлалт таван засал” “Зүү засал” хичээлүүдийн өрөө “Хулж-боржигон” түшиц эмнэлгийн заслын өрөө, ТТК-ийн оюутны байрны 315, 316 тоотод байрлаж байна.
- “Уламжлалт таван засал” хичээлийн дадлагын хичээлийг байгалийн үзэсгэлэнт газар болох “Шаргалжуут”, “Аварга тосон”, “Хужирт”, “Оргил” рашаан сувилал зэрэг газруудыг түшиглэн явуулж байна.

## Эмнэл зүйн тэнхмийн танилцуулга

### I. Эмнэл зүйн тэнхмийн түүх

Эмнэл зүйн тэнхим нь 2004 оны 9 сард 4 багштайгаар байгуулагдсан ба энэ үед тэнхмийн бүрэлдэхүүнд: тэнхмийн эрхлэгчээр Б.Мэндбаяр /клиникийн профессор/, Л. Алтанхуяг /АУ-ы магистр, дотрын багш/, Л.Сосорбарам /мэс заслын багш/, Д.Агваандорж /АУ-ы доктор, клиникийн профессор, хүүхдийн өвчин судлалын багш/ нар ажиллаж байв. 2004 оны 12-р сараас дотрын багш П.Отгонтогос нэмэгдэж ажилласан.



Тус тэнхимийн зорилго нь Уламжлалт анагаах ухааны чиглэлээр суралцаж байгаа оюутнуудад орчин үеийн анагаах ухааны суурь мэдлэг болон мэргэжлийн хичээлүүдийг өнөөгийн тавигдаж шаардлагат нийцүүлэн чанартай заан эзэмшүүлж, аль нэгэн мэргэжлээр ажиллах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг бие даан явуулах чадвартай эмч, мэргэжилтэн, судлаач бэлтгэхэд оршино.

### II. Тэнхимд харъяалагдах лаборатори, техник хэрэгслийн тухай

- Тус сургуулийн бааз эмнэлэг болох “Хулжборжигон” эмнэлэг энэ жилд 3 удаагаа магадлан итгэмжлэгдсэн.
- Тус тэнхим ТТАХНЭ, ХУД-ийн ЭМН, Энэрэл эмнэлэг, КТЭ-ийн цус, дотоод шүүрлийн булчирхайн клиник, уушги судлалын клиник, ЭНЭШТ-ийн эх барих, эмэгтэйчүүдийн клиник, ХСҮТ, ХӨСҮТ зэрэг клиникийн төв эмнэлгүүд түүний тасгуудтай хамтран ажиллах гэрээтэй ажиллаж байна.
- 2010 онд тэнхимд 3-н иж бүрэн компьютер /Pentium-IV/, нэг принтер /LaserJet 1018/, нэг сканер ашиглаж байна.
- Тэнхмийн 4 багш хувийн “Notebook”-тэй болсон.
- Тэнхмийн багш нар лекцээ видео проектор ашиглан уншиж байгаа
- Эмнэлзүйн бааз эмнэлгүүд дээр тус бүрт дадлагын хичээл орох өрөөтэй болсон

20. Нүдний өвчин судлал
21. НАС
22. Сэтгэцийн эмгэг судлал
23. Арьс, БЗХӨС
24. Хавдар судлал
25. Халдварт өвчин судлал
26. Эм судлал
27. Тархвар судлал

Эмнэлзүйн тэнхим хичээлийн 3-р байранд байрладаг.

### **NCM анагаах ухааны тэнхимийн түүх**

“Монос” дээд сургуулийн эрдэмтэн багш нарын дэвшүүлж буй “шинэ кодолсон анагаах ухаан” хэмээх шинэ санааг сургалтын технологит үе шаттайгаар бүрэн нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Монос” дээд сургуулийн захирлын 2009 оны 7-р сарын нэгний 64 тоот тушаалаар **“Newly codod medicine”** тэнхим байгуулагдсан.

#### **“Newly codod medicine” тэнхимийн зорилго**

Уламжлалт ба орчин үеийн анагаах ухааныг ЭШБТ гэсэн дундач кодын хүрээнд нэгтгэн зангидаж, интегратив тогтолцоонд оруулснаар “NCM” анагаах ухаан хэмээн томъёологдсон шинэ анагаах ухааны чиглэлийг бий болгож эмч, судлаачыг дэлхийн анагаах ухааны түүхэнд анх удаа бэлтгэн гаргана.

#### **“Newly codod medicine” тэнхимийн алтан үг**

“... ЭШБТ-ыг гаргаснаараа бид эс ба хий шар бадганыг ойртуулсан. Гэхдээ бид зарим хүний боддог шиг хий шар бадган нь эсийг орлодог гэж ойртуулаагүй, харин эсийг кодлодог гэж ойртуулсан ...”

#### **“Newly codod medicine” Тэнхимийн бүрэлдэхүүн**

1. Тэнхимийн зөвлөх багш М.Амбага Монгол улсын төрийн шагналт, Анагаахын шинжлэх ухааны доктор, Профессор, Grand doctor, pull professor.
2. Тэнхимийн эрхлэгч С.Нансалмаа Анагаах ухааны магистр
3. Багш Ж.Наранцэцэг Анагаах ухааны магистр
4. Багш Д.Аръяа Анагаах ухааны магистр
5. Багш Д.Шагдарсүрэн Анагаах ухааны магистр
6. Багш Б.Наранцэцэг Анагаах ухааны магистр
7. Багш Б.Ариунцэцэг Анагаах ухааны магистр

**“МОНОС” ДЭЭД СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Салбар:	Анагаах ухаан
Мэргэжил:	Уламжлалт анагаах ухаан
Боловсролын зэрэг:	Бакалавр
Мэргэжлийн индекс:	D 720700
Мэргэжлийн цол:	УА-ны хүний их эмч
Элсэгчдийн боловсролын түвшин:	Бүрэн дунд
Суралцах хугацаа:	6 жил
Нийт багц цаг:	209.5
Сургалтын хэлбэр:	Өдөр

3.Мэргэшүүлэх суурь /МШС/									
TDP-316	1	Уламжлалт эмийн жор судлал	5	80	3.5	32	48		
TIM-411	2	Уламжлалт дотрын өвчин судлал -1	8	144	6.5	64	80		
TIM-503	3	Уламжлалт дотрын өвчин судлал -2	9	144	6.5	64	80		
TTM-504	4	Уламжлалт засал	9	144	6.0	48	96		
ACM-505	5	Зүү, төөнө засал	10	192	8.0	64	128		
RHE-506	6	Нөхөн үржихүйн эрүүл мэнд	10	40	2.0	24	16		
ICR-507	7	Яаралтай тусламж	10	56	2.5	24	32		
PED-508	8	Хүүхдийн өвчин судлал	10	88	4.0	40	48		
OBS-509	9	Эх барих судлал	10	56	2.5	24	32		
INF-601	10	Халдварт өвчин судлал	11	56	2.5	24	32		
THD-602	11	Халуун өвчин	11	48	2.5	32	16		
ONC-603	12	Хавдар судлал, хөнгөвчлөх эмчилгээний үндэс	11	56	2.5	24	32		
GYN-604	13	Эмэгтэйчүүдийн өвчин судлал	11	56	2.5	24	32		
FAM-605	14	Өрхийн анагаах ухаан	12	144	6.5	64	80		
MASBTM-606	15	УАУС-ын эмнэлзүйн аспект	12	64	3.0	32	32		
		Бүгд		<b>1368</b>	<b>61.0</b>	<b>584</b>	<b>784</b>		
		<b>Нийт дүн</b>		<b>4768</b>	<b>209.5</b>	<b>1936</b>	<b>2672</b>	<b>160</b>	

зохицуулгын түвшинд сайтар судлагдан, нотлогдсон тохиолдолд л төлөвшин бий болно гэдгийг бүрэн ойлгож, энэ чиглэлээр эрэл хайгуул хийдэг чадамжтай.

6. Оношлогоо-эмчилгээний өдөр тутмын ажилдаа өвчтөн хүмүүс дээр Докам-1 программчлаллаар эсийн доторхи цөм байрлал дээрхи ХШБ код буюу мембран-редокси потенциалын 3 төлөвт шугамын төлөв байдал (B), эсийн гаднах-бүрхүүл байрлал дээрхи ХШБ код буюу мембран-редокси потенциалын 3 төлөвт шугамын төлөв байдлыг (B) тодорхойлон, бодис энергийн солилцоо, иммунобиологийн 12 хэлбэршлийг гаргасны дараа тэдгээрийн зүгээс 5 гол мембран, 5 гол үйл ажиллагаа плазмийн мембранд харгалдсан мэдээлэл хариу урвал үйл ажиллагаа, бөөмийн мембранд харгалдсан ген удамшихуйн үйл ажиллагаа, рибосомийн мембранд харгалдсан нийлэгжилт-дахин нийлэгжилтийн үйл ажиллагааны хүрээний зохицуулгын түвшингийн эмгэг үзэгдэлд буюу А-д үзүүлэх нөлөөллийг А-гаас Б, Б-ээс В, В-гээс А гэсэн эрэмбээр тогтоодог шинэ шийдлийг ойлгон ухаарч, өдөр тутмын ажилдаа нэвтрүүлэн, төгс эзэмшиж чадсан.
7. Оношлогоо-эмчилгээний өдөр тутмын ажилдаа эмийн бэлдмэлүүд “эмийн 2 үйлдвэр” шинэ концепцийн дагууд prodrug эмүүд “исэлдэлт-ангидролиз-фосфоржилтийн” урвалын дагууд drug болж хувиран идэвхиждэг зүй тогтлыг ашиглан, өвчтөн хүмүүс дээр Докам-1 программчлалаар эсийн доторхи цөм байрлал дээрхи ХШБ код буюу мембран-редоксипотенциалын 3 төлөвт шугамын төлөв байдал (B), эсийн гаднах-бүрхүүл байрлал дээрхи ХШБ код буюу мембран-редокси потенциалын 3 төлөвт шугамын төлөв байдлыг (B) тогтоосон үзүүлэлтийн дагууд энэ зүй тогтлыг хэрэгжүүлдэг шинэ шийдлийг ойлгож, ухааран, өдөр тутмын ажилдаа нэвтрүүлэх боломжийг сүвэгчилдэг.
8. Тухайн сум, орон нутаг, популяцийн хүрээнд positive конституцитэй буюу “БДТГТТХХИП+БГТДТТХХИП” гэсэн тоон өгөгдөхүүний утга нь хэвийн хэмжээнээс багагүй, БДТГТТХХИП:БГТДТТХХИП харьцаа өндөртэй, BMI:БДТГТТХХИП харьцаа багатай, булчингийн индекс:БГТДТТХХИП харьцаа өндөртэй, үүнтэй холбоотойгоор антиоксидант хамгаалах тогтолцооны чадамж өндөр, дархлалын хариу урвал зөв эрчимжих боломжтой, мембран дээр альфагаас бетта, беттагаас альфа, гамма төлөвийн шилжилтийн хурд болох ред-ээс окси, окси-гоос ред, редокси сул чиглэл рүү өөрчлөгдөх мэдрэмжийн сэлгэлтүүд, “АТФ:НАДФН:дулаан” гэсэн энергийн гол 3 хэлбэрийн харьцааны констант шилжилтийн утга нь гадаад, дотоод орчны өөрчлөгдөн байгаа шинэ, шинэ нөхцөл байдалтай маш уян, харимхайгаар зохицох хөдлөл зүй сайтай, оюуны болон биеийн ажиллах чадвар өндөртэй, чихрийн шижин, хэт таргалалт, артерийн судасны дутагдал, хорт хавдар, склерозод өртөх магдлал багатай харьцангуй эрүүл хүнийг олж илрүүлэх болон negative конституцитэй буюу БДТГТТХХИП+БГТДТТХХИП гэсэн тоон өгөгдөхүүн хэвийн хэмжээнээс багагүй ч гэсэн, БДТГТТХХИП:БГТДТТХХИП харьцаа багатай, BMI:БДТГТТХХИП харьцаа өндөртэй, Булчингийн индекс:БГТДТТХХИП харьцаа багатай, мөн “БДТГТТХХИП+БГТДТТХХИП” гэсэн тоон өгөгдөхүүн хэвийн хэмжээнээс багатай, үүнтэй холбоотойгоор антиоксидант хамгаалах тогтолцооны чадамж сул, дархлалын хариу урвал зөв эрчимжих боломж багатай, мембран дээр альфа-гаас бетта, бетта-гаас альфа, гамма төлөвийн шилжилтийн хурд болох ред-ээс окси, окси-гоос ред, редокси сул чиглэл рүү өөрчлөгдөх мэдрэмжийн сэлгэлтүүд, “АТФ:НАДФН:дулаан” гэсэн энергийн гол 3 хэлбэрийн харьцааны констант шилжилтийн утга нь гадаад, дотоод орчны өөрчлөгдөн байгаа шинэ, шинэ нөхцөл байдалтай маш уян,

**“Монос” анагаах ухааны дээд сургуулийг уламжлалт анагаах ухааны салбараар**

**төгсөгчийн “мэдлэг-чадвар-хандлага”- ын загвар**

**I. Онолын мэдлэг, практик чадамжийн хувьд:**

1. Түвд хэлээр “Анагаах ухааны дөрвөн үндэс” судрын түвшинд орчуулга хийх бүрэн чадамжтай бөгөөд тэр нь улсын шалгалтаар баталгаажсан, англи хэлээр мэргэжлийн ном чөлөөтэй ашигладаг, тэр нь улсын шалгалтаар баталгаажсан, орос хэлээр мэргэжлийн ном чөлөөтэй ашигладаг бөгөөд өвчний түүхийг уг хэл дээр хөтлөх чадамжтай.
2. Уламжлалт анагаах ухааны оношлогоо, зүү төөнүүр засал, уламжлалт дотор өвчний оношлогоо, эмчилгээ, эмт бодисыг MNS 2008- стандартын дагууд хэрэглэх, тусламж үйлчилгээ үзүүлэх чадамжтай.
3. УАУ-ы оношлогоо-эмчилгээний аргууд нь хүн төрөлхтний анагаах ухааны мэргэдийн 3000 жилийн өмнөөс бодож ирсэн “ $x+g+s=амьд$  эсийн эрүүл, эмгэг төрх, түүний оношлогоо, эмчилгээ” гэсэн тэгшитгэлийн “ $x+g...=үе$  шатны гайхамшигтай сайн бодолт шийдэлтэй гэдгийг ойлгохын хамт  $s$ -ийг ололгүйгээр  $x$  нь  $x$  ч юм шиг, мөн  $s$  ч юм шиг хоёрдмол ойлголтой байж болохгүй гэдгийг бүрэн ойлгосон
4. УАУ-ы сэтгэгчид 3000 жилийн өмнө  $s$ -ийг олоогүйг буруутгах ямар ч үндэсгүй, харин УАУ-ы өнөөдрийн хүмүүс  $s$ -ийг олох тухай бодох ч үгүй, мэдрэх ч үгүй байгааг зөвтгөх ямар ч үндэсгүй, үүнд л 2000 жилийн өмнөх УАУ-ы сэтгэгчид ба 21-р зууны УАУ-ы салбарын хүмүүсийн ялгаа байдаг гэсэн илэрхийллийг бүрнээ ойлгон сурах, судлах, оношлох, эмчлэх үйл ажиллагааандаа ханддаг.
5. УАУ-д амьд эсийн доторхи мембран-редокси потенциалын 3 төлөвт шугам хамааралт үзэгдлүүдийг ХШБ-аар кодолсон болохыг тогтоосноор УАУ ба ОУАУ-ы онол, оношлогоо, эмчилгээний аргуудыг нэг ерөнхий хэлтэй (common language) болгож, NCM шинэ анагаах ухааны тогтолцоог бий болгосон гэдгийг ойлгосон.
6. Хүн төрөлхтний анагаах ухааны мэргэдийн 3000 жилийн өмнөөс бодож ирсэн “ $x+g+s=амьд$  эсийн эрүүл, эмгэг төрх, түүний оношлогоо, эмчилгээ” гэсэн тэгшитгэлийн бүрэн шийдлийг гаргасан NCM анагаах ухаан нь төгсөгчийг ёс зүй, хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгодог, “ $x+g+s=амьд$  эсийн эрүүл, эмгэг төрх, түүний оношлогоо, эмчилгээ” гэсэн тэгшитгэл дутуу бодолттой буюу  $s$  дутуу байгааг анзаарч мэдсэн тохиолдолд шинжлэх ухааны хатуу хүтүүг мэдэрч, уламжлалт анагаах ухааны сургалтын нарийн ээдрээтэй байдлыг ухааран ойлгож, эрдмийн ажлын төлөө яваа хүнийг хайрлах, хүндлэх сэтгэл үүсгэн, эрдмийн ажлыг сэтгэлээсээ хийхгүй, хөнгөн наазгай хандахын хор холбогдлыг ойлгон, хүмүүжиж, ёс зүйждэг гэдгийг бүрэн ойлгосон.
7. УАУ-ы оношлогоо-эмчилгээний аргууд, эм, засал, зүү төөнүүр заслын үйлдлийн мөн чанарыг “ $x+g+s=амьд$  эсийн эрүүл, эмгэг төрх, түүний оношлогоо, эмчилгээ” гэсэн тэгшитгэлийн “ $x+g$ ” гэсэн үе шатан дээр нь сонгодог УАУ-ы үүднээс ч мэддэг, гардан хийж чаддаг, мөн үүнийгээ  $s$  гэсэн шинэ гүнзгийрүүлсэн хувилбар дээр нь

плазмийн мембранд харгалдсан мэдээлэл хариу урвал үйл ажиллагаа, бөөмийн мембранд харгалдсан ген удамшихуйн үйл ажиллагаа, рибосомийн мембранд харгалдсан нийлэгжилт, дахин нийлэгжилтийн үйл ажиллагааны хүрээний зохицуулгын түвшингийн эмгэг үзэгдэлд буюу **А-д үзүүлэх нөлөөллийг А-гаас Б, Б-ээс В, В-гээс А гэсэн эрэмбээр тогтоодог** шинэ шийдлийг ойлгон ухаарч, өдөр тутмын ажилдаа нэвтрүүлэн, төгс эзэмшиж чадсан.

13. Оношлогоо-эмчилгээний өдөр тутмын ажилдаа эмийн бэлдмэлүүд “эмийн 2 үйлдвэр” шинэ концепцийн дагууд prodrug эмүүд “исэлдэлт-ангигралт-фосфоржилтийн” урвалын дагууд drug болж хувиран идэвхиждэг зүй тогтлыг ашиглан, өвчтөн хүмүүс дээр Докам-1 програмичлаллаар эсийн доторхи цөм байрлал дээрхи ХШБ код буюу мембран-редокси потенциалын 3 төлөвт шугамын төлөв байдал (**Б**), эсийн гаднах-бүрхүүл байрлал дээрхи ХШБ код буюу мембран-редокси потенциалын 3 төлөвт шугамын төлөв байдлыг (**В**) **тогтоосон үзүүлэлтийн дагууд энэ зүй тогтлыг** хэрэгжүүлдэг шинэ шийдлийг ойлгож, ухааран өдөр тутмын ажилдаа нэвтрүүлэх боломжийг сүвэгчилдэг.
14. Тухайн сум, орон нутаг, популяцийн хүрээнд positive конституцитэй буюу “БДТГТТХХИП+БГТДТТХХИП” гэсэн тоон өгөгдөхүүний утга нь хэвийн хэмжээнээс багагүй, БДТГТТХХИП:БГТДТТХХИП харьцаа өндөртэй, VMI:БДТГТТХХИП харьцаа багатай, булчингийн индекс:БГТДТТХХИП харьцаа өндөртэй, үүнтэй холбоотойгоор антиоксидант хамгаалах тогтолцооны чадамж өндөр, дархлалын хариу урвал зөв эрчимжих боломжтой, мембран дээр альфа-гаас бетта, бетта-гаас альфа, гамма төлөвийн шилжилтийн хурд болох ред-ээс окси, окси-гоос ред, редокси сул чиглэл рүү өөрчлөгдөх мэдрэмжийн сэлгэлтүүд, **“АТФ:НАДФН:дулаан”** гэсэн энергийн гол 3 хэлбэрийн харьцааны констант шилжилтийн утга нь гадаад, дотоод орчны өөрчлөгдөн байгаа шинэ, шинэ нөхцөл байдалтай маш уян, харимхайгаар зохицох хөдлөл зүй сайтай, оюуны болон биеийн ажиллах чадвар өндөртэй, чихрийн шижин, хэт таргалалт, артерийн судасны дутагдал, хорт хавдар, склерозод өртөх магадлал багатай харьцангуй эрүүл хүнийг олж илрүүлэх болон negative конституцитай буюу “БДТГТТХХИП+БГТДТТХХИП” гэсэн тоон өгөгдөхүүн хэвийн хэмжээнээс багагүй ч гэсэн, БДТГТТХХИП:БГТДТТХХИП харьцаа багатай, VMI:БДТГТТХХИП харьцаа өндөртэй, Булчингийн индекс:БГТДТТХХИП харьцаа багатай, мөн “БДТГТТХХИП+БГТДТТХХИП” гэсэн тоон өгөгдөхүүн хэвийн хэмжээнээс багатай, үүнтэй холбоотойгоор антиоксидант хамгаалах тогтолцооны чадамж сул, дархлалын хариу урвал зөв эрчимжих боломж багатай, мембран дээр альфа-гаас бетта, бетта-гаас альфа, гамма төлөвийн шилжилтийн хурд болох ред-ээс окси, окси-гоос ред, редокси сул чиглэл рүү өөрчлөгдөх мэдрэмжийн сэлгэлтүүд, **“АТФ:НАДФН:дулаан”** гэсэн энергийн гол 3 хэлбэрийн харьцааны констант шилжилтийн утга нь гадаад, дотоод орчны өөрчлөгдөн байгаа шинэ, шинэ нөхцөл байдалтай маш уян, харимхайгаар зохицох хөдлөл зүй удаантай, оюуны болон биеийн ажиллах чадвар өндөр биш, чихрийн шижин, хэт таргалалт, артерийн судасны дутагдал, хорт хавдар, склерозод өртөх магадлал өндөртэй харьцангуй эмгэг хэлбэршил бүхий хүнийг олж илрүүлэн, эрүүлжүүлэх арга хэмжээг авч явуулах чадамжийг эзэмшсэн.
15. Монос дээд сургуульд судалсан 60 гаруй хичээлийн агуулгыг “x+g+s=амьд эсийн эрүүл, эмгэг төрх, түүний оношлогоо, эмчилгээ” гэсэн тэгшитгэлийн “x+g...=үе шатанд УАУ-ы холбогдолтой бүх хичээлүүдийг, s-ийн хүрээнд биохими, биологи, физик,

потенциалын 3 төлөвт шугам дээр болон амьд эсийн доторхи ОУАУ-д илүүтэй судлагдсан, билгийн чанартай, 5гол мембран-5 гол үйл ажиллагаа плазмийн мембранд харгалдсан мэдээлэл хариу урвал үйл ажиллагаа, бөөмийн мембранд харгалдсан ген удамшихуйн үйл ажиллагаа, рибосомийн мембран дээр харгалдсан нийлэгжилт, дахин нийлэгжилтийн үйл ажиллагааны хүрээний зохицуулгын маш нарийн түвшинд тавиад, харин **эмчилгээг** маш энгийн буюу амралт, нойр хоол, иога, пневмо дасгал зэрэг “мембран-редокси потенциалын 3 төлөвт шугам дээр АТФ зэрэг энергийн гол эх булаг, макроэрг нэдлүүдийн хэрэгцээ шаардлагын багасахаас эхлэн эмчилдэг зарчимд суралцан бүрэн эзэмшсэн байх.

## II. Иргэний төлөвшилт, ёс суртахууны хувьд:

Эмчийн ёс суртахуун, энэрэнгүй үзлийн талаархи Буддын гүн ухаан, билиг бармидын сургаал, уламжлалт зарчмыг эмчийн деонтологийн орчин үеийн зарчмуудтай зөв хослуулан ойлгож, ухамсарлан өвчтөнтэй хандах, харьцах оношлогоо, эмчилгээний өдөр тутмын ажил амьдралдаа мөрдлөг болгосон эмчийн алдаа, оноог нүгэл, буяны хүрээнд дэнслэн ойлгож эмчилгээ, оношлогооны аливаа асуудалд хийсвэрээр бус шинжлэх ухаанчаар хандаж, амьдралын утга учраа өвчтөн хүнийг эдгээн илааршуулахтай холбож чаддаг байх.

### “Монос” дээд сургуулийн оюутны шилжилт хөдөлгөөний тухай журам

#### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Оюутныг сургалтаас түр болон бүрмөсөн чөлөөлөх, улираах, түр чөлөөнөөс эргэн суралцуулах, үргэлжлүүлэн суралцуулах тухай асуудлыг шийдвэрлэхэд энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Оюутан хүндэтгэх шалтгааны улмаас 30 хүртэлх хоногоор хичээлээс чөлөөлөгдвөл Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, чөлөөг бичгээр өгнө.
- 1.3. Оюутныг сургалтаас түр чөлөөлөх, дамжаа улираах, түр чөлөөнөөс эргэн суралцуулах, үргэлжлүүлэн суралцуулах, сургуулиас гаргах, бүрмөсөн чөлөөлөх тухай үндэслэлийг Оюутны алба боловсруулж, сургуулийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 1.4. Элсэлтийн уралдаант шалгалтын онооны дарааллаар анх сонгосон мэргэжлээ солихгүй.

#### Хоёр. Оюутныг сургалтаас түр чөлөөлөх тухай

- 2.1. Эрүүл мэнд, ахуй амьдрал, бусад хүндэтгэх шалтгааныг үндэслэн зөвхөн шалгалт, шүүлгийн тооцоогүй оюутанд сургалтаас түр чөлөө олгоно.
- 2.2. Түр чөлөө авах тухай хүсэлтийг оюутан өөрөө Оюутны албанд хандаж бичгээр гаргана.
- 2.3. Түр чөлөө авч буй оюутан сургалтын төлбөрийг бүрэн төлсөн, сургуулийн номын сан болон группын ахлагчаас ном сурах бичиг болон бусад тооцоогүй гэсэн бичгүүдийг өргөдөлтэй хавсаргасан байна.

- 5.1. Их, дээд сургууль, коллеж төгсөөд элсэж буй тохиолдолд:
  - 5.1.1. Анагаахын чиглэлийн их, дээд сургууль төгссөн, бүх суралцах хугацааны үнэлгээ нь “В”-ээс доошгүй бол 3-р курсээс элсүүлэн суралцуулж болно.
  - 5.1.2. Анагаахын чиглэлийн дунд сургууль, коллеж төгссөн, бүх суралцах хугацааны үнэлгээ нь “В”-ээс доошгүй бол 2-р курсээс, “В” үнэлгээнд хүрэхгүй бол 1-р курсээс элсүүлэн суралцуулна.
  - 5.1.3. Анагаахын чиглэлийн бус их, дээд сургууль төгсөөд элсэхийг хүсэж буй элсэгчдийг 2-р курсээс элсүүлэн суралцуулна.
  - 5.1.4. Анагаахын чиглэлийн бус коллеж төгсөөд элсэхийг хүсэж буй элсэгчдийг 1-р курсээс элсүүлэн суралцуулна.
- 5.2. Их, дээд сургууль, коллежоос шилжиж ирэх тохиолдолд:
  - 5.2.1. Шилжиж ирж байгаа оюутан нь “Монос” дээд сургуультай ижил мэргэжлээр сургалт явуулдаг, манай сургуультай сургалтын бодлогын хувьд нэгдсэн тогтолцоонд орсон гадаад, дотоодын их, дээд сургуулиас шилжин ирж байгаа бол тухайн курст авах ёстой нийт кредитын 60-аас багагүй хувийг биелүүлсэн тохиолдолд зөрүү хичээлийг нөхүүлэн тухайн курст нь шилжүүлэн авч суралцуулна.
  - 5.2.2. Өмнө нь суралцаж байсан гадаад, дотоодын коллеж нь манай сургуультай ижил чиглэлийн мэргэжлээр сургалт явуулдаг бол нэг курс доошлуулан суралцуулна.
  - 5.2.3. Өмнө нь суралцаж байсан гадаад, дотоодын их, дээд сургууль нь анагаахын чиглэлийн бус бол (гэхдээ мал эмнэлэг, биологи зэрэг байгалийн ухааны чиглэлийн байвал) кредитийн зөрүүг харгалзан зөвхөн 1 эсвэл 2-р курст элсүүлэн суралцуулна.
- 5.3. Үргэлжлүүлэн суралцагч нь өмнө нь сурч байсан сургуулиас түр завсардснаас хойш 3 жилийн дотор өөрийн сурч байсан мэргэжлээрээ үргэлжлүүлэн суралцах эрхтэй ба үргэлжлүүлэн суралцах хүсэлтээ сургуулийн захиргаанд бичгээр гарган шийдвэрлүүлнэ.
- 5.4. Үргэлжлүүлэн суралцахаар ирүүлсэн өргөдөл, холбогдох материалыг (сургууль төгссөн диплом, сургуулиас чөлөөгдсөн тухай тушаал, дүнгийн тодорхойлолт) Оюутны алба нарийвчлан судлаж, сургуулийн захиргаанд танилцуулж, үргэлжлүүлэн суралцуулах шийдвэр гаргуулж, захирлын тушаалаар баталгаажуулна.
- 5.5. Өмнө нь сурч байгаад чөлөөлөгдсөн дамжаандаа үргэлжлүүлэн суралцах шийдвэр гарвал сургалтын хөтөлбөрийн зөрүүг гаргаж, тооцоо дууссан тохиолдолд дамжаа дэвших болзол биелүүлсэн гэж үзнэ.
- 5.6. Тухайн жилийн сургалтын төлбөрийг тогтоосон хугацаанд сургуулийн дансанд хийнэ.
- 5.7. Сургалтын төлбөрийг сургуулийн дансанд тушаасан санхүүгийн баримтыг үндэслэн үргэлжлүүлэн суралцуулах тухай албан ёсны зөвшөөрөл өгч суралцуулна.
- 5.8. Үргэлжлүүлэн суралцагч нь бусад оюутны нэгэн адил сургуультай оюутан сургах тухай гэрээ хийж, түүнийг мөрдлөг болгоно.

- 6.4. Сургуулиас бүрмөсөн чөлөөлөгдсөн оюутныг үргэлжлүүлэн суралцуулах тухай асуудлыг зөвхөн элсэлтийн уралдаант шалгалтын журмаар шийдвэрлэнэ.
- 6.5. Сургалтын төлбөрөө бүрэн төлөөд суралцаж буй оюутан ямар нэг шалтгаанаар тус сургуульд үргэлжлүүлэн суралцах боломжгүй болвол сургалтын төлбөрийг эргүүлэн олгохгүй.

### “Монос” дээд сургуулийн оюутны мэдлэг чадварыг

#### үнэлэх журам

#### Нийтлэг үндэслэл

БСШУЯ-ы сайдын 2003 оны 158 дугаар тушаалын “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэхэд баримтлах журам”-ыг үндэслэн энэхүү журмыг боловсрууллаа.

Оюутан суралцагчдын үнэлгээний нэгдсэн систем нь “сурах, сургах” үйл ажиллагааг бодитой үнэлэх, сургалтын үйл явцыг удирдах, зохицуулах, нэгдсэн бодлого хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Оюутны мэдлэгийн үнэлгээний тогтолцоо хоёр үе шаттай байна. Үүнд:

**А. Явцын буюу багшийн үнэлгээ.** Оюутан улирлын туршид сурах идэвхи чармайлт, өөрийгөө дайчлах, сэтгэлгээгээ хөгжүүлэх талаар ямар түвшинд байсныг тухайн хичээл заасан багш **70 хүртэл оноогоор** дүгнэнэ.

70 онооны үнэлгээний бүтэц:

1	<b>ирц</b>	<b>10 оноо</b>
2	<b>идэвхи</b> (хичээлийн оролцоо, хичээлд санаачлага гарган оролцох байдал, сэтгэмжлэх байдал)	<b>5 оноо</b>
3	<b>Явц:</b>	<b>55 оноо:</b>
	➤ сорил	...
	➤ аман ярилцлага	...
	➤ лабораторийн ажил	...
	➤ бие даалт	...
	➤ бусад	...

Явцын үнэлгээг тооцох аргачлал:

1. Тухайн хичээлийн явцад хэдэн багц сэдвүүд үзэх, сэдвүүдийн дагуу хэдийд сэдвийн шүүлэг, сорил, аман ярилцлага, лабораторийн ажил, бие даалтын аль хэлбэрээр нь явцын үнэлгээг тооцохыг багш бүр өөр өөрийн заадаг хичээлээр урьдчилан боловсруулж Сургалтын албаар батлуулсан байх шаардлагатай.
2. Энэхүү боловсруулсан үнэлгээний аргачлалаа хичээлийн эхэнд буюу анхны хичээл дээр оюутнуудад тодорхой мэдээлнэ.
3. Оюутан эхний явцын шалгалтанд хангалтгүй буюу F үнэлгээ авсан тохиолдолд дараагийн шатны явцын шалгалтанд орохгүй.

**1-р хэсэг** нь оюутны заавал мэдвэл зохих ерөнхий ойлголт, тодорхойлолтыг шалгасан асуултуудаас бүрдэнэ. Энэ хэсэгт зөв буруу хариулт бүхий аман асуулт хариулт, сорил байх ба тухайн хичээлээр заавал эзэмшвэл зохих мэдлэг, дадлага, хандлагыг **ТИЙМ, үгүй** гэсэн хариултаар шалгана.

**2-р хэсэг нь** оюутан асуултанд бичиж, бодож хариулах, эцсийн зөв хариултыг сонгох гэсэн дэс дараалалтай байх ба тухайн хичээлийн үндсэн агуулгаар оюутны мэдлэг чадамж дэлхийн аль ч улс орны анагаах ухаан, уламжлалт анагаах ухаан, эм зүйн сургалтанд олгогддог стандарт мэдлэгийн хүрээнд байгаа эсэхийг шалгана.

**3-р хэсэг нь** тухайн хичээлээр тухайн оюутан олж авсан мэдлэг дээр тулгуурлан шинэ санаа, сэтгэлгээ, сэтгэмжийн олон хувилбарт асуудал дэвшүүлсэн үед зөв шийдэл гаргаж байгаа байдлыг дүгнэнэ.

Дээрхи 3 хэсэгт харгалзах оноо асуултын хүнд хөнгөнөөс шалтгаалж харилцан адилгүй байна.

Явцын үнэлгээ ба улирлын шалгалтын нийлбэр 100 оноог лавлах хүснэгтийг ашиглан үсгэн үнэлгээнд шилжүүлнэ.

Процентон үнэлгээ	Үсгэн үнэлгээ	Тоон тоо
90-100	A	4.0
80-89	B	3.0
70-79	C	2.0
60-69	D	1.0
0-59	F	0

Үнэлгээний голч дүнг тооцохдоо хичээл бүрийн үсгэн үнэлгээг тоонд шилжүүлэн улмаар тухайн хичээлийн харгалзах кредитээр үржүүлж, дундчилах замаар тодорхойлно.

$$Y_1K_1 + Y_2K_2 + \dots + Y_nK_n$$

Үнэлгээний голч дүн =

$$K_1 + K_2 + \dots + K_n$$

$Y_1, Y_2 \dots Y_n - 1, 2 \dots n$  - дугаар хичээлүүдийн үнэлгээний оноо

$K_1, K_2 \dots K_n - 1, 2 \dots n$  - дугаар хичээлүүдийн харгалзах кредит

- 1.8. Сургуулийн орчинд хар тамхи, архидан согтууруулах ундаа биедээ авч явсан буюу хэрэглэсэн.
- 1.9. Сургуулийн өмчид хамаарах хөрөнгө, ном сурах бичиг, эд зүйлс, тоног төхөөрөмжийг зориулалтын бус байдлаар ашигласан, гэмтээсэн.
- 1.10. Сургуулийн аюулгүйн болон бусад онцгой байдлын тоног төхөөрөмжийг буруугаар ашигласан, тэдгээрт гэмтэл хохирол учруулсан, хариуцсан ажилтны үйл ажиллагаанд саад учруулсан.
- 1.11. Сургуулийн байр, эзэмшилд нэвтрэн орох түлхүүр, карт, кодыг зөвшөөрөлгүйгээр ашигласан, бусдад дамжуулсан.
- 1.12. Сургалтын гэрээ болон сургуулийн дүрэм, журмын заалтыг зөрчсөн, тэдгээрээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй.
- 1.13. Энэхүү дүрмийн заалтуудыг удаа дараалан зөрчсөн.

#### **4. Сахилгын зөрчил гаргасан оюутанд дараах арга хэмжээг авна. Үүнд:**

- 4.1. Амаар буюу бичгээр анхааруулах.
- 4.2. Эрхийг хязгаарлах, оюутны байрнаас гаргах, диплом олгохыг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, сургуулиас олгосон биеийн байцаалт болон сургуулийн бусад өмч хөрөнгийг хураах, хохирлыг төлүүлэх.
- 4.3. Тодорхой нөхцөлтэйгээр үргэлжүүлэн суралцуулах.
- 4.4. Тодорхой хугацаагаар суралцах эрхийг нь хасах.
- 4.5. Сургууль, хамт олны өмч, эд хөрөнгө, аюулгүй байдал, сургалтын хэвийн үйл ажиллагаанд учруулсан хохирлын хэмжээнээс шалтгаалан сургуулийн захиргаа тухайн оюутныг сургуулийн Ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэлгүйгээр сургуулиас хөөж болно. Энэ арга хэмжээг дараах тохиолдолд авна. Үүнд:
  - Зөрчил удаа дараа давтагдсан.
  - Сургуульд их хэмжээний хохирол учруулсан, нэр төрд нь халдсан гэж үзвэл.

#### **Гурав. Ёс зүйн зөвлөл**

1. Сургууль нь Ёс зүйн зөвлөлтэй байна. Зөвлөлийн хурлаар ёс зүйн дүрмийг зөрчсөн оюутны асуудлыг хэлэлцэн зөвлөмж гаргаж, сургуулийн захиргаанд өгнө. Хурлыг ил тод, нээлттэй, шударга зарчмаар явуулна.
2. Уг дүрмийн дагуу арга хэмжээ тооцогдсон оюутан нь хариуцлагыг хүлээн зөвшөөрөх үндэслэлгүй гэж үзвэл МОХ-ны дэргэдэх ёс зүйн хороонд хандах эрхтэй.
3. Оюутны эрхийг хамгаалах үүднээс Ёс зүйн хороо нь асуудлыг дахин хэлэлцэж, тайлбарыг нь сонсож, өмнөх шийдвэрийг өөрчилж болно.

биохими, иммунологийн шинжилгээ, зүрхний цахилгаан бичлэг, рентген, эхографийн зураглалд дүгнэлт өгч тухайн өвчтөн дээр УАУ ба орчин үеийн анагаах ухааны оношлогоо, эмчилгээний нэгдмэл нийцэлд хэвтээ босоо тэнхлэгийг бий болгосон байдлаар эцсийн дүн тавигдана.

ЭЗ-н салбарын оюутнууд мэргэжүүлэх хичээлийн гардан хийх ажилбар буюу “х” бодисын химийн шинжилгээ, ялган танилт технологи, стандартчлалт, эм бэлтгэх эмийн сангийн ба үйлдвэрлэлийн нөхцөлд гүйцэтгэх үйлдэлийг биеэр үзүүлж эцсийн дүнгээ авна.

Тодруулж хэлбэл, УАУ-ы салбарын оюутан тухайн салбарын мэргэжлийн багш нараас бүрдсэн УАУ-ы оношлогоо, эмчилгээ, дотор, мэс засал, эх барих, эмэгтэйчүүд, хүүхэд, лаборатори, зүрхний цахилгаан бичлэг, рентген гэсэн 18 хэсэгт өөрийн ур чадвараа үнэлүүлнэ. Хэсэг тус бүр дээр тодорхой даалгавартай билет сугалан гардан ажилбар хийх буюу шинжилгээнд дүгнэлт өгөх бөгөөд тус бүр 10 минут, нийт шалгалтын хугацаа 1 цаг 10 минут байна. Аль хэсгээс эхлэн шалгалт өгөх дараалал, хугацааг оюутанд мэдэгдсэн шалгалтын хуудсыг тэдэнд өгнө.

ЭЗ-н салбарын оюутан жороор эм бэлдэх, эмийг орцын дагуу бэлдэх, спектрометр болон аналитик жин дээр ажиллах, уусмалын чанар, тогтворжилтыг үзүүлэх, алкалоид, флаваноидын чанарын урвал явуулах, зах зээл судлалын тодорхой асуудлаар шалгуулна.

Шалгалтын комиссын гишүүд оюутны мэдлэгийг рейтинг оноогоор үнэлэх ба шалгалтын эцэст нийт гишүүдийн рейтинг онооны дундажаар дадлагын шалгалтын дүнг тогтоож, түүнд харгалзах А, В, С, D, F үнэлгээ өгнө.

Дипломын хавсралтад төгсөлтийн онолын ба дадлагын шалгалтын дүнг тусад нь бичнэ.

4. Төгсөлтийн шалгалтанд D, F дүн авсан буюу суралцсан хугацааны голч дүн 2.0 хүрэхгүй оюутанд анагаах ухааны дээд боловсролын диплом олгохгүй.
5. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан бүх хичээлийн 75%-иас доошгүй хувьд нь “А”, бусдад нь “В” үнэлэлттэй суралцсан, төгсөлтийн шалгалтаа “А” үнэлгээтэй өгсөн оюутанд онцгойлох диплом олгоно.

### **Гурав. Төгсөлтийн шалгалтын комисс**

1. Төгсөлтийн шалгалтын комиссыг тухайн салбар, мэргэжлийн багш, эрдэмтэд оролцсон 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, захирлын тушаалаар батална.
2. Төгсөлтийн шалгалтын комиссын үндсэн үүрэг нь төгсөгчийн мэдлэг, чадварын түвшин анагаах ухааны боловсролын стандартын шаардлагад хэрхэн нийцэж байгаа талаар иж бүрэн үнэлгээ өгөх, төгсөлтийн шалгалтын дүнг үндэслэн төгсөгчдөд анагаах ухааны дээд боловсрол, мэргэжил эзэмшсэнийг гэрчлэх диплом олгох асуудлыг шийдвэрлэх, суралцагчдын сурлагын чанарыг сайжруулах санал, зөвлөмж боловсруулахад оршино.

3. Нэрэмжит шагнал хүртэгч оюутан нь бүх талаараа жишиг үлгэрлэхүйц хэв шинжтэй, анги хамт олондоо үлгэр жишээч, хошуучлагч, сургуулийн захиргаа, оюутны холбооноос зохиогддог ажилд идэвхитэй оролцогч байх
4. Нэрэмжит шагнал хүртэгч оюутны нэр дээр хичээл заасан бүх багш нар санал өгөх бөгөөд дүнг гуйж дээшлүүлэх мэтийн ёс зүйн алдаа гаргаагүй байх

Энэ болзолыг 2005-2006 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөх ба үүнээс өмнөх 2 жилийн сурлагын дүнг оролцуулан дүгнэнэ.

“Лүнрэг Дандар”-ын нэрэмжит стипенди авах болзол хангасан оюутанд 200 000 төгрөгний урамшуулалт стипендийг нэг удаа олгох ба уг цолыг сургуулийн хүндэт самбарт байрлуулж мөнхөлнө. Үүнээс цааш үргэлжлүүлэн онц суралцсан УАУ-ы ба ЭЗ-н хэсгийн оюутнуудад “Монос” дээд сургуулийн захирлын нэрэмжит, “Монос” эмийн үйлдвэрийн нэрэмжит стипендийг тус тус олгож байна.

### **Төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг**

#### **төрөөс санхүүжүүлэх журам**

##### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Өмчийн бүх хэлбэрийн их сургууль, коллежийн дипломын болон бакалаврын шатлалд төрийн албан хаагчийн гэр бүлээс өдрийн ангид элсэн суралцаж байгаа нэг хүүхэд (цаашид оюутан гэнэ)-ийн сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.
2. Төрийн албан хаагчийн гэр бүл гэж Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төрийн албан тушаалын ангилал, төрлийг үндэслэн Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад орсон албан тушаалыг хашиж байгаа эцэг, эх (цаашид төрийн албан хаагч гэнэ)-ийг хэлнэ.
3. Төрийн албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн зөвхөн нэг оюутны сургалтын төлбөрийг төрөөс олгоно. Төрийн албанаас халагдсан, чөлөөлөгдсөн тохиолдолд оюутны сургалтын төлбөрийн санхүүжилтийг зээлийн буюу бусад хэлбэрт шилжүүлнэ.
4. Оюутан дипломын шатлалд суралцах бол 90 кредит цагийн, бакалаврын шатлалд суралцах бол 120 кредит цагийн сургалтын төлбөрийг төр хариуцан санхүүжүүлнэ.
5. Оюутан нь их сургууль, коллежид элсэн суралцах эрхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу авсан байна.

#### **Хоёр. Оюутны сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэхэд төрийн албан хаагчийн бүрдүүлэх материал**

6. Төрийн албан хаагч нь ажиллаж буй төсөвт байгууллагадаа доорхи материалыг бүрдүүлж өгнө. Үүнд:

14. Их сургууль, коллежид суралцаж байгаа оюутны төлбөрийг санхүүжүүлэхдээ дотоодын төрийн өмчийн их сургууль, коллежийн адилтгах мэргэжлийн дээд боловсрол эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийн зардлын хэмжээг баримтлана.
15. Оюутан нь Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу гадаадын их сургууль, коллежид суралцсан тохиолдолд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн энэ журмын 9 дүгээр заалтад заасан гэрээнд “сургалтын төлбөрийг төр хариуцсан” гэсэн тэмдэглэгээ хийж сургалтын төлбөрийн гэрээг дуусгавар болсонд тооцно.
16. Төрийн албан хаагч хүүхдийнхээ сургалтын төлбөрийг өөрөө төлсөн тохиолдолд энэ журмын 6 дугаар заалтад заасан материал мөнгө тушаасан баримтыг үндэслэн ажиллаж буй байгууллагаар нь дамжуулан Сургалтын төрийн сангаас төлбөрийг нөхөн олгоно.
17. Оюутан зохих журмын дагуу чөлөөтэй байсан хугацааны сургалтын төлбөрийн санхүүжилтийг түргэлзүүлэх бөгөөд үргэлжлүүлэн суралцах үед нь сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлнэ.

#### **Дөрөв. Бусад асуудал**

18. Оюутан сургалтын төлбөрийн талаар хуурамч материал бүрдүүлсэн, сургуулиас хасагдсаныг нуун дарагдуулсан, төлбөрийг нь давхардуулан авсан, илүү олгосон зэрэг зөрчил гаргасан тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу дээд боловсролын, төсөвт байгууллага болон аймаг, дүүргийн Засагдарга, Сургалтын төрийн сангийн холбогдох албан тушаалтан төрийн албан хаагчдад хариуцлага хүлээлгэнэ.
19. Хоёр дахь дээд боловсрол эзэмшихийг хүссэн тохиолдолд энэхүү журам үйлчлэхгүй.
20. Оюутны сургалтын төлбөрийн санхүүжилттэй холбоотой талуудын хооронд гарсан маргааныг боловсролын хяналт эрхэлсэн байгууллага гомдлыг нь хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.
21. Их сургууль, коллежид төрийн зардлаар суралцаж байгаа оюутан сургуулиас хасагдсан, өөр сургуульд шилжин суралцсан тохиолдолд төрийн албан хаагчийн бусад хүүхдэд сургалтын төлбөрийг шилжүүлж болохгүй.

#### **Дотоодын их сургууль, коллежид суралцаж байгаа зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам**

##### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Өмчийн бүх хэлбэрийн магадлан итгэмжлэгдсэн их сургууль, коллежид 2000-2001 оны хичээлийн жилээс эхлэн зохих журмын дагуу элссэн нэн ядуу, малчин, 3 ба түүнээс дээш хүүхэд нь дээр дурьдсан сургуулийн өдрийн ангид суралцаж байгаа нэг суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

10. Их сургууль, коллежиос ирүүлсэн материалыг Сургалтын төрийн сан хянан үзэж, шаардагдах санхүүжилтийг сургууль тус бүрээр улирлын хуваарийн дагуу санхүүжүүлнэ.
11. Суралцагч нь улиралд 12-оос доошгүй кредит цагийн ачаалалтай, улирлын голч дүн 2-оос дээш байгаа нөхцөлд гэрээг сунгана.
12. Давтан үзэх хичээлийн сургалтын төлбөрийг суралцагч өөрөө хариуцна. Тухайн хичээлийн жилд цуглуулбал зохих кредитээс илүү гаргаж сонгосон хичээлийн сургалтын төлбөрийг суралцагч өөрөө хариуцна.

#### **Дөрөв. Бусад асуудал**

13. Суралцагч хуурамч материал бүрдүүлсэн нь тогтоогдвол түүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхээс гадна хөнгөлт үзүүлэхгүй.
14. Хоёр дахь дээд боловсрол эзэмшихийг хүссэн тохиолдолд энэхүү журам үйлчлэхгүй.
15. Суралцагч нь сурлага сахилга батаар тэнцээгүй гэсэн шалтгаанаар сургуулиас хасагдсан тохиолдолд тухайн суралцагч төрөөс санхүүжүүлсэн сургалтын төлбөрийг Сургалтын төрийн санд буцааж төлнө.

#### **Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй**

##### **тусламж олгох, эргэн төлүүлэх журам**

#### **Нэг. Нийтлэг зүйл**

1. Боловсролын хуулийн дагуу 2002 оны 10-р сарын 08-ны өдрийн 207-р тогтоолоор өөрчлөгдснөөр магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежийн оюутан, магистрант, докторант, Засгийн газрын гэрээ, хэлэлцээрээр гадаадад суралцагчид (цаашид “суралцагч” гэнэ) сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.
2. Боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран сургалтын төлбөрийн зээл болон буцалтгүй тусламжаар суралцах суралцагчдын тоог жил бүрийн 5 дугаар сарад мэргэжил тус бүрээр нь батлан гаргана.
3. Дээд боловсролын агуулгын багтаамжийг хэмжих нэгж нь кредитцаг байна. Нэг кредит цаг нь улирлын туршид нэг долоо хоногт танхимд нэг цагаар орох лекц буюу 2 цагаар орох семинар, дадлага эсвэл 3 цагаар орох лабораторийн ажлын нийт цагтай тэнцүү тоон утгаар хэмжигдэнэ.
4. Их дээд сургууль, коллеж нь суралцагчдын кредит цагийн өртгийг үндэслэн тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хэмжээг сургуулийн Удирдах зөвлөлийн хурлаар батлуулж 6 дугаар сард нийтэд зарлана.
5. Суралцагчдын улирлын болон суралцсан хугацааны агуулга эзэмшилтийн чанарын төвшинг тогтооход голч дүнг ашиглана. Голч дүн нь дээрх хугацаанд үзсэн хичээлд авсан тоон дүнгийн кредит цагаар жигнэгдсэн дундаж байна.

10. Төрийн захиргааны ба үйлчилгээний байгууллага (цаашид “захилагч” гэнэ)-ын захилгаар Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаад оронд суралцагч болон тус улсын их дээд сургууль, коллежийн магистрантур, докторантурт суралцагч нь тэдгээрийн суралцуулагч байгууллага, Сургалтын төрийн сантай гурвалсан хэлбэрээр гэрээ байгуулж нотариатаар гэрчилнэ.
11. Сургалтын төрийн сан нь хичээлийн жилийн улирал тутамд суралцагчийн сурлагын талаар сургуулиудаас ирүүлсэн тодорхойлолт болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан голч дүнг үндэслэн зээл, тусламжийн гэрээгсунгаж баталгаажуулна.
12. Их дээд сургууль, коллежийн нягтлан бодогч, суралцагчийн авсан зээл тусламжийг зээлийн гэрээ, картад бичилт хийн тухайн хичээлийн жилийн улирал бүрийн эцэст Сургалтын төрийн сантай тооцоо нийлж гурвалсан гэрээний сунгалт болон төгсөгчдийн төлбөрийн хаалт хийнэ.
13. Тус улсын их сургууль, коллежид сургалтын төлбөрийн зээл, тусламжийн гэрээгээр суралцагч Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрээр гадаадад шилжин суралцах үед түүний Сургалтын төрийн санд төлөгдөх сургалтын төлбөрийг зээлээр үргэлжлүүлэн олгож болно.
14. Сургалтын төрийн сан, сургууль, суралцагчийн хооронд байгуулах гэрээнд сургалтын төлбөрийн зээл, тусламж олгох,эргэж төлүүлэх талаар гэрээлэгч талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгана.
15. Сургалтын төрийн сан, захиалагч, суралцагчийн хооронд байгуулах гэрээнд тухайн суралцагчийн суралцах хугацаа,түүний ажлын байр болон сургалтын төлбөрийн зээлийгэргэн төлүүлэх талаар талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгана.
16. Сургалтын төлбөрийн зээл, тусламжийн гэрээнийзагварыг Боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

### **Дөрөв. Сургалтын төлбөрийн зээл, тусламж авахад**

#### **суралцагчийн бүрдүүлэх материал**

17. Сургалтын төлбөрийн зээл болон буцалтгүй тусламж авахдаа суралцагч дараах материалыг бүрдүүлнэ:
  - а. Их сургууль, коллежид элссэнийг нотлох элсэлтийн комиссоос олгосон томилолт, магистрантур, докторантурт суралцуулах тухай сургуулийн шийдвэр, Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр гадаадын их сургуульд суралцуулах тухай Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр,
  - б. Сургалтын төлбөрийн зээл, тусламж хүссэн болон түүнийг буцааж төлөх тухай нотолсон суралцагч эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гараар бичсэн өргөдөл,
  - в. Иргэний үнэмлэхийн хуулбар,
  - г. Энэхүү журмын 7-гийн б-д заасан суралцагчийн хувьд эцэг, эх, асран хамгаалагч нь нас барсан тухай гэрчилгээний хуулбар,
  - д. Зээлийн төлбөрийн хөрөнгийн баталгааны нотариатын гэрчилгээ

в. Суралцсан хугацаанд авбал зохих кредит цагийг бүрэн биелүүлж, дараалсан 4 улирлын голч дүн нь 3.8-аас дээш амжилт үзүүлсэн оюутанд энэхүү хугацаанд,

г. Суралцсан хугацаандаа авбал зохих кредит цагийг бүрэн биелүүлж, эхний жилийн голч дүнгээрээ 3.8-аас дээш амжилт үзүүлсэн болон тухайн сургууль, их сургууль, коллежийн хэмжээнд зохиогддог эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж, шилдэг бүтээлээр шалгарсан магистрант, эрдэм шинжилгээний тодорхой хэсэг нь үйлдвэрлэлд нэвтэрч үр дүн нь гарч байгаа докторантад хамгаалах хүртэлх хугацаанд.

24. Суралцагч хүүхэд төрүүлсэн болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар зохих журмын дагуу чөлөө авсан бол зээлийн гэрээг түдгэлзүүлэн сургалтын төлбөр, тэтгэлгийн санхүүжилтийг түр зогсооно.

### **Зургаа. Сургалтын төлбрийн зээлийг төлүүлэх, барагдуулах тухай**

25. Сургалтын төлбөрийн зээл, тусламжаар суралцагч сургуулиа төгссөн, эсхүл гэрээлэгч талуудын аль нэг нь гэрээг цуцалсан буюу түдгэлзүүлэх бол тухайн суралцуулагчийг сургаж буй сургуулиас энэ тухай Сургалтын төрийн санд ажлын 10 өдрийн дотор албан ёсоор мэдэгдэнэ.
26. Сургалтын төлбөрийн зээлээр суралцагч сургуулиас хасагдсан, сургуулиа орхисон тохиолдолд тухайн сургууль нь Сургалтын төрийн санд ажлын 5 өдрийн дотор энэ тухай албан ёсоор мэдэгдэнэ. Хэрэв энэ тухай мэдэгдээгүй бол тухайн сургуулиас зээл, тусламжаар суралцагчийн дараа улирлын санхүүжилтээс суутгал хийнэ.
27. Уг журмын 24-р заалтаас бусад шалтгаанаар суралцагч цаашид суралцахгүй болсон тохиолдолд сургалтын төлбөрийн зээл, тусламж, тэтгэлгийг зогсоож суралцахгүй болсон тухайн сараас эхлэн жилийн 3 хувийн хүүтэйгээр 2 жилийн дотор буцааж төлүүлнэ. Хүүгээс хүү тооцохгүй.
28. Сургалтын төрийн сан хичээлийн жилийн улирал тутам уг журмын 11-д заасны дагуу сурлагын байдлын талаархи сургуулийн тодорхойлолтыг үндэслэн зээл, тусламжаар суралцагчийн гэрээг түдгэлзүүлж, дахин сэргээж болно.
29. Зээлээр суралцагч нь сургалтын хөтөлбөрийг бүрэн дуусмагц төгссөгсөн сургууль зээлийн картанд зээлийн бичилтийг бүрэн хийж, уг суралцагчаар гарын үсэн зуруулан дипломын хамт Сургалтын төрийн санд албан ёсоор хүлээлгэн өгнө.
30. Суралцагч сургалтын төлбөрийн зээлийг сургууль төгссөнөөс хойш 10 жилийн дотор бүрэн төлж барагдуулна. Ингэхдээ эхний 6 жилийн дотор хүүгүй, долоо дахь жилээс эхлэн арилжааны банкны жилийн дундаж хүүгээс 0.5-иар илүү хүүтэйгээр 4 жилийн дотор зээл, хүүгийн хамт төлнө.
31. Суралцагч сургууль төгсөөд төрийн захиргаа, үйлчилгээний болон дээд боловсрол олгох байгууллагатай хөдөлмөрийн гэрээний дагуу эзэмшсэн мэргэжлээрээ 5 жил үр бүтээлтэй ажилласан бол тухайн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн сургалтын төлбөрийн зээлийг чөлөөлж болно. Чөлөөлөх асуудлыг Сургалтын төрийн сангийн Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

2. Сургуулийн томилолт
3. Оюутны иргэний үнэмлэхний хуулбар
4. Эцэг, эхийн нас барагсадын гэрчилгээний хуулбар
5. Оюутны группын дэвтэрийн хуулбар
6. Өрхийн амьжиргааны түвшин баталгаажих түвшингээс 40 хувиас доогуур байгааг баталсан харъяалагдах хорооны даргын болон сум, аймгийн Засаг даргын Тамгын газрын тодорхойлолт

**Төрийн сангаас сургалтын төлбөрийн санхүүжилт авахад:**

1. Оюутны өргөдөл (ямар нөхцөлийн дагуу сургалтын төлбөрийн санхүүжилт авах хүсэлтэй байгаа болон өөрийн ар гэрийн амьдралыг тодорхой бөгөөд үнэн бодитоор бичиж өгнө.)
2. Сургуулийн томилолт
3. Сум, аймгийн засаг даргын тодорхойлолт
4. Тухайн оны мал тооллогын бичиг баримт
5. Өрхийн амьжиргааны түвшин баталгаажих түвшингээс 40 хувиас доогуур байгааг баталсан харъяалагдах хорооны даргын болон сум, аймгийн Засаг даргын Тамгын газрын тодорхойлолт
6. Өрхийн 3 ба түүнээс дээш хүүхэд их дээд сургууль, коллежид зэрэг суралцдаг бол тэдгээр оюутнуудын сургуулийн тодорхойлолт, томилолтын хуулбар
7. Өрхийн аль нэгэн гишүүн тахир дутуу бол түүнийг батлах группын дэвтэрийн хуулбар
8. Эцэг, эхийн иргэний үнэмлэхний хуулбар
9. Эцэг, эх нь өндөр насны тэтгэвэрт гарсан бол тэтгэвэрийн дэвтэрийн хуулбар

Дээрхи материалыг оюутан тухайн хичээлийн жилийн 9-р сарын 20-ны дотор бүрдүүлж сургуулийн ОА-д өгнө. Сургууль Сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох журмын 3.8-р заалтын дагуу комисс байгуулж, тухайн жилд суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, тусламж олгох асуудлыг Сургалтын төрийн сангаас өгсөн хяналтын тоонд багтаан шийдвэрлэх үүрэг хүлээнэ.

## Оюутан гэж хэн бэ?

### Өрсөлдөх чадвар ба монгол хүн

Даяарчлалын энэ цаг үед бидний амьдарч байгаа гариг дэлхий маань, Монгол эх орон маань хором хормоор өөрчлөгдөн хөгжиж, шинэ бэрхшээл, шинэ хөгжил, шинэ технологи, мэдээллийн үсрэнгүй шинэ дэвшил, шихнэ зорилтыг хором хормоор бидний өмнө дэвшүүлж тулган хүлээлгэж байна. Энэ нь улс орон бүхэн хүн ардаа боловсролтой болгохыг, аймаг сум, баг бүхэн иргэдээ хөгжүүлэхийг, төр засгаас хүнээ хөгжүүлэх цэгцтэй бодлого явуулахыг шаардаж байна. Даяарчлалын орон зай газар сайгүй шургаж энэ дэлхий ертөнцөд нэг хүн ч, нэг баг сум, аймаг ч, нэг улс гүрэн ч нийгмийн амьдарлын бүх хүрээн дэх өрсөлдөөний давалгаанд дуртай ч дүргүй ч орж, чиний ч миний ч маргаашийн идэх хоол, өмсөх хувцас, хэрэглээг өршөөлгүй хатуу энэ нийгэмд өрсөлдөн амьдрах чадвараар хэмжих боллоо. Аливаа улс орны тогтвортой хөгжил дэвшилд нөлөөлдөг эерэг хүчин зүйлсийн нэг нь ард иргэдийн соёл иргэншлийн хөгжингүй төвшин, амьдрах чадвар мөн гэж эдийн засагчид үздэг. Тэрхүү амьдрах чадварын гол агуулга нь хүн бүрийн өрсөлдөх чадвар. Мэдлэгээрээ ч, ажиллах чадвараар ч, бие дааж сурах чадвараар ч, ер нь бүх талаар тэмцэн амьдрах хэрэгтэй гэдгийг өнөөгийн нийгэм, даяарчлал мөч тутамд бидэнд сануулсаар байна. Мэдлэгт тулгуурласан эдийн засгийг хөгжүүлэх үндэс нь мэдлэг, бүтээх чадвар мөн. Хүний хөгжлийг бүтээх чадвараар хэмждэг. Чанартай мэдлэг, бүтээх чадвар болж чадах мэдлэгтэй мэргэжилтэн бол улс орны өрсөлдөх чадварыг тодорхойлно. Ширүүн өрсөлдөөн, инновацийн эрин үед монгол хүн бүхэн өрсөлдөх чадвараа хөгжүүлж дээшлүүлэх нь нийгэм эдийн засаг, амьдралаа өөд нь татах арга төдийгүй, тусгаар тогтнолоо авран хамгаалах замаар даяарчлалд тэсэж тогтох хамгийн шалгарсан арга байж ч мэдэх юм.

Оюутан бол маргаашийн мэргэжилтэн. Мэргэжилтний өрсөлдөх чадвар гэдэг бол мэргэжлийн мэдлэг, ур чадвар, бэлтгэлжилт, иргэний төлөвшилтөөрөө зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж байх өндөр түвшин юм. Хэн өрсөлдөн амьдрах чадвар сайн байна, мэдээж тэр хүн сайн сайхан амьдарна. Ингэхлээр өрсөлдөх чадвар гээчийг насны багаас өөртөө өвлөж ээмшиж төлөвшүүлж чадсан хүн ирээдүйд сайхан амьдрахын эрхийг гартаа атгах нь лавтай.

Хүн ардын сайн сайхан гэрэлт ирээдүй, эх орондоо эрх чөлөөт ардчилсан нийгмийг цогцлон байгуулах үйлс маань хөгжсөн Монгол хүн, Монгол мэргэжилтний өндөр чанар, эзэмшсэн мэдлэгээ хэрэгжүүлэх боломжоос ихээхэн шалтгаална. Хүнээ хөгжүүлэх, хүнээ чадваржуулах гэдэг бол зах зээлийн өнөөгийн нөхцөлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, ажилгүйдлийг арилгах, ядуурлаас гарах цорын ганц зам мөн ажээ. Оюутны хөгжил, залуу хүний өрсөлдөх өндөр чадвар гэдэг бол нийгмийн хөгжил, шинэчлэлийн тэргүүн эгнээнд байх чадвар, мэдлэгт суурилсан хөгжлийн тулгуур үндэс мөн.

Залуу хүн яах гэж их, дээд сургуульд элсэн суралцдаг вэ? Мэргэжил эзэмшихээс гадна мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд өөрийгөө нээн хөгжүүлж өөрийн чадавхиа амьдралд хэрэгжүүлэх боломжоо олж, амьдралд байр сууриа олох гэж, өрсөлдөн амьдрах чадваруудыг эзэмших гэж суралцдаг.

Залуу хүний өрсөлдөх чадваруудад юу багтах вэ?

1. Гадаад хэлний боловсрол

энэ нөөц, эрч хүч, боломжийг манай зарим залуус ухаарч ойлгоогүй, оюутан гэж өөрийгөө ухамсарлаж чадаагүй, тэр хэрээр өөрийгөө шавхан дайчлах эр зориг, сэтгэлийн тэнхээ маруухан дээд сургуулийн босгыг алхаж орох нь ажиглагддаг. Дээд боловсрол эзэмшинэ гэдэг нь Дипломтой болохын нэр биш, эх орондоо баялаг бүтээгч иргэний чанаруудыг өөртөө төлөвшүүлнэ гэсэн үг. Юм бүхнийг сурах гэж бүх цагаа үрэх биш насан туршдаа суралцах арга барилыг эзэмшихэд анхаарлаа төлөврүүлбэл зохино. Энэхүү бие даан суралцах чадвар бол ахих насны оюуны чадавхи, оюуны баялгийн эх булаг юм. Нөгөө талаар бие даан суралцах чадварыг эзэмшиж чадвал өрсөлдөн амьдрах чадвараа цаг тутамд дээшлүүлж чадна. Бие даан суралцах чадварыг эзэмшинэ гэдэг бол оюутан өөрийн чөлөөт цагаа оновчтой зохицуулж чаддаг байх учиртай. Өрөөр хэлбэл өөрийнхөө өмнө тавьсан зорилготой, түүнийгээ хэрэгжүүлэн биелүүлэхийн тулд чөлөөт цаг, хүч хөдөлмөрөө зөв зохион байгуулж чаддаг, идэвхи чармайлттай, өөрийгөө өөрчлөх өөрийнхөө сул тал, хоцрогдлыг ялахын төлөө ухамсартайгаар зүтгэж хичээж яваа хүнийг л жинхэнэ оюутан гэнэ. Жинхэнэ оюутан болж чадалгүй оюутан нэр зүүсээр байж байгаад зорилгодоо хүрэхгүй замаасаа няцаж, буцдаг залуус ч байдаг. Тэд бол сонголтоо буруу хийсэн хэрэг. Оюутан гэдэг орчин цаг үеээсээ хоцролгүй хором бүр эрдэм оюун, иргэнлэг сэтгэлийн оргил өөд тэмүүлж байгаа хүн. Энэхүү оргилд гагцхүү сурах соёлыг, суралцах арга ухааныг, бие дааж ажиллах чадварыг эзэмшсэн хүн л хүрч чаддагийг үе үеийн оюутан мэргэдийн жишээнээс харж болно. “Ганцхан мөч алдвал бусдаас хол хоцорно” гэж яруу найрагч Ян Неруда хэлсэн байдаг. Мөч хором бүр хувьсан өөрчлөгдөж байгаа энэ ертөнцөд та бага залуугаасаа эрдэм ухааныг эрхэмлэн амьдралын ухаанаас цаг алдалгүй суралцахын чухлыг сургамжилж байгаа нь энэ юм. Энэ ертөнцийн гайхамшиг нь хүн, хүний суу гайхамшиг нь оюун ухаан. Оюун ухааныг гайхамшиг болгодог мөнхийн түлхүүр нь эрдэм мэдлэгт оршдог. Мэдлэг ол. Танаас хэн ч булааж үл болох, бусадтай хуваалцах тусам өргөждөг, та хэзээд ч хэрэглэх боломжтой.

### **Дээд сургуулийн сургалт ямар онцлогтой вэ?**

Таны элсэн суралцаж байгаа сургууль бол боловсрол олгох, соён гэгээрүүлэх, шинжлэх ухаан үйлдвэрлэлийн олон жилийн баялаг уламжлалтай сургалтын байгууллага юм. Их дээд сургуулийн босгыг алхан орно гэдэг бол та цоо шинэ хүн болохоор зорьж ирсэн нийгэмд хамгийн тэргүүн эгнээний оюунлаг хүмүүсийн шинэ ертөнцөд, шинэ хүрээлэлд хөл тавьж байна гэсэн үг.

Та ямар орчинд орж ирэв ээ?

1. Таны оюутан болж цаашид хэрхэн суралцах нь өмнө эзэмшсэн суурь мэдлэгийн төвшин, чанараас шууд шалтгаална. Суурь мэдлэгийн түвшин доогуур байх нь сурлагаар доголдох нэг шалтгаан байдаг бөгөөд гагцхүү уйгагүй хөдөлмөр, нөхөх давтлага хувийн оролдлогоор гүйцээж авна.
2. Их, дээд сургуулийн босгоор алхсан эхний үед их завтай болчихсон юм шиг санагдана. Гэтэл тийш биш. Гагцхүү суралцах хүний өөрийнх нь идэвхи санаачлага ухамсарт сургалтын үйл ажиллагаанд тулгуурлах учир байнгын өдөр тутмын няхуур, нямбай, жигд ажиллагаа, хувийн зохион байгуулалт, цагаа зөв хувиарлах явдлыг танаас шаарддаг.
3. Оюутнаас биеэ дааж ажиллах өндөр ур чадварыг шаарддаг. Оюутны хөдөлмөр, мэдлэгийг үнэлэх систем нь ч оюутны бие даасан үйл ажиллагаанд тулгуурладаг.

### Тэмдэглэлт өдрүүд

1. Эрдмийн баяр – 9-р сарын 01
2. Танилцах үдэшлэг – 1-р улирлын III-IV долоо хоног
3. Сургуулийн спортын наадам – 1-р улирлын VII долоо хоног
4. Сургуулийн урлагын наадам – 1-р улирлын IX долоо хоног
5. Олон улсын оюутны өдөр – 11-р сарын 17
6. “ЭШБТ-ийг хэн сайн ойлгож,ашиглаж чадах вэ?” уралдаан – 11-12-р сар
7. Улс тунхагласны баяр – 11-р сарын 26
8. Цасны баяр – 1-р улирлын XIV-XV долоо хоног
9. Шинэ жилийн баяр – 1-р сарын 1
10. 1-р улирлын шалгалт – 1-р улирлын XVIII-XX долоо хоногууд
11. Өвлийн амралт – Цагаан сараар
12. Багш нарын баяр – 2-р сарын эхний бүтэн сайн өдөр
13. Хонхны баяр, Төгсөгчдийн тангараг өргөх ёслол – 3-р сарын эхэнд
14. Эмэгтэйчүүдийн баяр – 3-р сарын 8
15. Цэргийн баяр – 3-р сарын 18
16. Монос дээд сургуулийн нэрэмжит химийн олимпиад – 2-р улирлын II-IV долоо хоног
17. “Эрин зууны анагаах ухааны шинэ хандлага” Оюутны эрдэм шинжилгээний бага хурал – 2-р улирлын X долоо хоног
18. “Мэдлэг-сэтгэмж-хурд” тэмцээн – 2-р улирлын VI долоо хоног
19. 2-р улирлын шалгалт- 2-р улирлын XVIII-XIX долоо хоног

